



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Болдын УЯНГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-62, Факс: 32-70-16
E-mail: uyanga@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026 09 11 № 94X-05/9856
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Миний бие Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Б.Жаргалан нарын хамтаар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай” анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б.УЯНГА

Б.МӨНХСОЁЛ

Б.ЖАРГАЛАН

000151



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Болдын УЯНГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-62, Факс: 32-70-16
E-mail: uyanga@parliament.mn
http://www.parliament.mn

2026.07.22 № УИХ-03/8688
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай” анхдагч хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Б.Жаргалан нарын хамтаар санаачлан боловсрууллаа.

Хуулийн төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос санал авахаар 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн УИХ-03/4683, УИХ-03/4684 дугаартай албан бичгүүдийг хүргүүлсэн бөгөөд Улсын дээд шүүхээс хариу ирүүлээгүй байна.

Улсын ерөнхий прокурорын болон хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхэд ирүүлсэн саналыг тоймлон хуулийн төсөлд тусган ажилласан болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулга болон холбогдох судалгааг хавсаргав.

Хавсралт 166 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.УЯНГА

000166